НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ
2026 ОН



Гүйцэтгэсэн: Б.Батбаяр (Ph.D.)
Т.Золбоо (Ph.D.)
Р.Хатансайхан (LL.M.)

АГУУЛГА

УДИРТГАЛ **4**

i. Судалгааны зорилго 4

ii. Судалгааны хүрээ 4

iii. Зардлын төрөл 10

iv. Хүснэгтийн жагсаалт 11

1. ЦАХИМ ШИЛЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ **12**

1.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох 12

2. АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ **14**

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох 15

2.2. Хүний нөөцийг тодорхойлох 17

2.3. Үүсэх зардлыг урьдчилан тооцох 20

2.4. Үр дүнг тооцох 21

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах 23

3. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД ЗАРДАЛ **24**

3.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох 25

3.2. Хүний нөөцийг тодорхойлох 27

3.3. Үүсэх зардлыг урьдчилан тооцох 30

3.4. Үр дүнг тооцох 31

3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах 33

ДҮГНЭЛТ **34**

НОМ ЗҮЙ **36**

УДИРТГАЛ

Монгол Улсад номын сангийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, сан хөмрөг, хүний нөөц, санхүүжилт, хэрэглэгчийн эрх, цахим шилжилт шилжилт, мэргэжлийн хөгжлийг дэмжих, номын сангийн үйлчилгээгээр иргэн бүрийн мэдлэг, мэдээлэл, боловсрол, соёлд тэгш хүртээмжтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, соён гэгээрүүлэх, тогтвортой хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилгоор “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулжээ.

Тус хуулийн төсөл нь долоо бүлэг, 34 зүйлээс бүрдэнэ. Эдгээр бүлгээр зохицуулах харилцаанд *Төрөөс номын сангийн үйл ажиллагааг дэмжих бодлого, зарчим, Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг үүсгэх байгуулах, татан буулгах, Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн эрх, үүрэг, Номын сангийн холбоо, гишүүнчлэл, Номын сангийн төрөл, Сан хөмрөгийн бүрдүүлэлт, Номын сангийн заавал авах хувь, Худалдан авах үйл ажиллагаа, Сан хөмрөгийн бүртгэл, тооллого, Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, Түүх, соёлын дурсгалт зүйлийг ашиглуулах, Сэргээн засварлах, нөхөн бүрдүүлэх, Номын сан ба хүний хөгжил, унших соёл, Цахим номын сангийн үйл ажиллагаа ба сан хөмрөг, Цахим номын сангийн үйлчилгээ ба мэдээллийн аюулгүй байдал, Дижитал бичиг үсгийг хөгжүүлэх, Номын сангийн ажилтны эрх, үүрэг, Номын сангийн ажилтны нийгмийн баталгаа, Уншигчийн эрх, үүрэг, Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэг, Засгийн газрын бүрэн эрх, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх* зэргийг хамруулжээ.

i. Судалгааны зорилго

Уг судалгаагаар “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бодит зардлыг тооцон, холбогдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахад оршино.

ii. Судалгааны хүрээ

2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд 1500 гаруй номын сан үйл ажиллагаа явуулж байгаагаас нийтийн номын сан 363, ерөнхий боловсролын сургуулын номын сан 844, байгууллагын дэргэд 120, их дээд сургуулийн дэргэдэх 101, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн номын сан 54, эрдэм шинжилгээний номын сан 44, хүүхдийн номын сан 1 ажиллаж байна. [1]

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.1-д заасан “анхдагч хуулийн төсөл” байна.[2] “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төсөлд заасан ихэнх харилцааг одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2014 оны Номын сангийн тухай хуулиар зохицуулжээ.[3]

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төсөл болон Номын сангийн тухай хуулийн зохицуулалтыг харьцуулбал;

[1] Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2025, 14 дэх тал
[2] Хууль тогтоомжийн тухай хууль, 2015, https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119
[3] Номын сангийн тухай хууль, 2014, https://legalinfo.mn/mn/detail/10844

Хүснэгт 1. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөл болон 2014 оны Номын сангийн тухай хуулийн харьцуулалт

№	Төслийн зүйлийн дугаар	Агуулга	2014 оны Номын сангийн тухай хуулийн харгалзах зүйл	Тайлбар
1.	1	Хуулийн зорилго, зорилт	1	Ижил зорилготой; төслийн 1.1-д “дижитал шилжилт, мэргэжлийн хөгжлийг дэмжих” гэсэн нэмэлт орсноос бусад агуулга ижил.
2.	2	Дагаж мөрдөх хууль тогтоомжийн жагсаалт	2	Үндсэн бүтэц ижил; төсөлд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах”, “Цахим харилцааны тухай” хуулиудыг нэмсэн.
3.	3.1.1, 3.1.6, 3.1.10, 3.1.11, 3.1.13-3.1.16	Үндсэн нэр томьёо: номын сан, уншигч/уншигч-хэрэглэгч, тусгай бүлгийн уншигч, үндэсний, нийтийн, эрдэм шинжилгээний/академик, тусгай номын сангийн тодорхойлолт	3.1	Тодорхойлолтын үндсэн санаа давхцана; нэр томьёо “уншигч” → “уншигч-хэрэглэгч” болж өргөжсөн.
4.	5.1	Хуулийн үйлчлэх хүрээ, өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш үйлчлэх	Хуулийн ерөнхий үйлчлэх хүрээний заалт	Агуулга давхцана.
5.	6.2, 6.3	Номын сан үүсгэн байгуулах эрх бүхий этгээд (төрийн, орон нутгийн, гадаад, ТББ, иргэн)	5.1	Агуулга төстэй.
6.	6.4-6.6	Төрийн/орон нутгийн өмчийн номын сан татан буулгах, шилжүүлэх зарчим	5.4, 5.5 (ойролцоо)	Үндсэн зарчим (татан буулгахгүй, сан хөмрөгийг өөр номын санд шилжүүлэх) давхцана.
7.	6.7, 14.1-14.3	Орон тооны бус Номын сангийн зөвлөл, Эрдмийн болон Мэргэжлийн зөвлөл	8	Зөвлөлийн орон тооны бус, зөвлөх шинжүүд ижил. Төсөлд зөвлөлийн чиг үүргийг арга зүйн төв тус бүрт задлан тодорхойлсон.
8.	9.1.2, 9.1.4, 9.1.6	Номын сангийн үндсэн ангилал: нийтийн, эрдэм шинжилгээ/академик, тусгай	10	Ангиллын үндсэн бүтэц ижил.
9.	10.1, 10.2	Нийтийн номын сангийн тодорхойлолт, чиг үүрэг	10.1, 10.2	Үг үсгийн хувьд ойролцоо; “орон нутгийн мэдээллийн нээлттэй орон зай” гэсэн шинэ илэрхийлэл нэмэгдсэн.
10	15.2-15.3	Үйлчилгээний төрөл: уншлагын танхим, гэрээр	11.2, 11.3	Үйлчилгээний төрлүүд төстэй. Цахим номын сангийн үйлчилгээг төсөлд “үндсэн

№	Төслийн зүйлийн дугаар	Агуулга	2014 оны Номын сангийн тухай хуулийн харгалзах зүйл	Тайлбар
		ном олгох, зөөврийн номын сан, ном зүй, лавлагаа, тусгай бүлгийн уншигчийн үйлчилгээ		үйлчилгээ”-д, хуучин хуульд “нэмэлт үйлчилгээ”-д тооцож байсан зэрэг ангиллын зарим ялгаа бий.
11	16.1, 16.2	Сан хөмрөгийн бүрдүүлэлтийн эх үүсвэр: заавал авах хувь, худалдан авалт, нөхөн бүрдүүлэлт, солилцоо, хандив, өв залгамжлал	16	Бүрэн давхцана.
12	17.1.1, 17.1.3	Заавал авах хувийн тоо: Үндэсний номын санд 5/2/2 ширхэг, орон нутгийн санд 3 ширхэг, 30 хоногийн дотор	17	Тоо, хугацаа бараг бүрэн давхцана (Үндэсний номын сан 5/2/2, орон нутгийн сан 3).
13	18.2	Дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл сурталчилсан бүтээл худалдан авахыг хориглох	18	Хориглох агуулга давхцана.
14	19.1	Сан хөмрөгийн бүртгэл, тооллогын хугацааг сан хөмрөгийн хэмжээ, зориулалтаас хамааруулан тогтоох	19	Давхцана.
15	20.1-20.3	Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт, стандартын шаардлага, гамшгийн үеийн журам, даатгуулах боломж	20	Үндсэн агуулга давхцана.
16	21.1, 21.2	Ховор, үнэт, ганц хувь бүтээлийг цахим/хуулбар хэлбэрээр ашиглуулах, эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр судалгаанд ашиглуулах	21	Давхцана.
17	22.1	Нэн яаралтай хамгаалах бүтээлийн жагсаалт батлах, сэргээн засварлах зардлыг улсын төсөвт тусгах	22	Давхцана.
18	27.1, 27.2	Номын сангийн ажилтны ерөнхий эрх, үүрэг (аюулгүй орчинд ажиллах, цалин хөлс	Ажилтны эрх, үүрэгтэй холбоотой ерөнхий заалт	Үндсэн санаа давхцана; төсөлд судлааач/сэдвийн номын санчийн тусгай үүргийг нэмж дэлгэрэнгүй болгосон (27.3, 27.4 — шинэ).

№	Төслийн зүйлийн дугаар	Агуулга	2014 оны Номын сангийн тухай хуулийн харгалзах зүйл	Тайлбар
		авах, ном хамгаалах үүрэг)		
19	29.1-29.5	Уншигчийн эрх, үүрэг: үнэ төлбөргүй үндсэн үйлчилгээ, стандарт орчин, гомдол гаргах, тусгай бүлгийн уншигчийн эрх, брайль/сонсдог ном, гэрээр ном олгох	14.1-14.3, 14.3.1-14.3.6	Уншигчийн эрхийн үндсэн жагсаалт (үнэ төлбөргүй, стандарт орчин, гомдол гаргах, соёл олон нийтийн ажилд оролцох) төстэй.
20	31.1-31.4	Засгийн газрын бүрэн эрх (хууль хэрэгжүүлэх, барилга хөгжүүлэх, хүүхдийн ном дэмжих, гамшгийн журам батлах)	Засгийн газрын бүрэн эрхийн ерөнхий заалт	Үндсэн чиг үүрэг давхцана.
21	32.1-32.6, 32.8	Соёлын асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрх: хууль хэрэгжүүлэх, бодлого/дүрэм батлах, ажилтны зэрэглэл тогтоох, стандарт батлуулах, судалгаа дэмжих	Байгууллагын бүрэн эрхийн ерөнхий заалт	Үндсэн чиг үүрэг давхцана; 32.7 (статистик нэгтгэх, хяналт-шинжилгээ) нь илүү тодорхой болсон шинэ хэсэг (доор үзнэ үү).
22	34.1	Хууль зөрчигчид Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх	Эцсийн зүйлийн хариуцлагын ерөнхий заалт	Давхцана.

Дээрх хүснэгтээс үзвэл Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн зохицуулалт нь 2014 оны Номын сангийн тухай хуулийн зохицуулалттай ижил болох нь харагдаж байна.

Хүснэгт 2.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих хуулийн төслөөр шинэчлэн зохицуулж буй харилцаа

№	Төслийн зүйлийн дугаар	Шинэ зохицуулалтын агуулга
1.	3.1.2-3.1.4	“Номын сангийн ажилтан”, “судлаач номын санч”, “сэдвийн номын санч” гэсэн шинэ ангилал, тодорхойлолт нэвтрүүлсэн.
2.	3.1.7-3.1.9	“Цахим номын сан”, “цахим мэдээллийн сан”, “цахим номын сангийн үйлчилгээ” гэсэн тусдаа тодорхойлолт нэмэгдсэн.
3.	3.1.12	“Тусгай грант” (буцаан төлөхгүй санхүүгийн дэмжлэг) гэсэн шинэ ойлголт.
4.	8	Номын санчдын мэргэжлийн холбоо, нийгэмлэг байгуулах эрх, үүнд төрөөс санхүүгийн, технологийн дэмжлэг үзүүлэх зохицуулалт шинээр тусгагдсан.
5.	9.1.5, 9.1.7	“Цахим номын сан”, “бусад номын сан (өрхийн, хувь хүний)” гэсэн шинэ ангилал.
6.	12.1-12.4	Академик номын сангийн тусгай зохион байгуулалт: сургалт судалгааны мэдээллийн эх сурвалж, мэдлэгийн удирдлагын орчин бүрдүүлэх чиг үүрэг, гишүүн номын сангуудын хамтын мэргэжил-арга зүйн төвтэй байх зохицуулалт бүхэлдээ шинэ.
7.	12.3	Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төвд нэгдсэн каталог, нэгдсэн цахим номын сан, цахим мэдээллийн сан үүсгэх, оюуны бүтээлийн хуулбарлалт шалгах программ хангамжийг нэгдмэл байдлаар нэвтрүүлэх, хиймэл оюун ухаан ашиглах ажлыг зохион байгуулах чиг үүргийн зохицуулалт шинэ.
8.	12.4	Судлаач номын санч, сэдвийн номын санчтай байх шаардлагыг академик номын санд тусгайлан тогтоосон.
9.	23.2.3, 23.2.4, 23.3	Хүүхэд, залуучуудад дижитал бичиг үсэг, программчлал, код бичих анхан шатны мэдлэг, цахим орчинд аюулгүй оролцох чадвар олгох хөтөлбөр; хиймэл оюун ухаан, программчлалын сургалт зохион байгуулах зохицуулалт шинээр нэмэгдсэн.
10.	24, 25, 26 (Дөрөвдүгээр бүлэг бүхэлдээ)	“Цахим номын сангийн үйл ажиллагаа” гэсэн тусдаа бүлэг: цахим хэлбэрт шилжүүлэх журам, зохиогчийн эрх эзэмшигчтэй гэрээ байгуулах, цахим сан хөмрөгийн төрөл, тусгай IP хаяг/лицензээр үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын бодлого, цахим бичиг үсгийн 5 бүрдэл хэсэг (мэдээллийн, харилцааны, техникийн, аюулгүй байдлын, бүтээлч байдлын) — эдгээр нь 2014 оны хуульд байхгүй, бүрэн шинэ зохицуулалт.
11.	27.3, 27.4	Судлаач номын санч (судалгааны арга зүй, ишлэл зүй, нөлөөллийн үзүүлэлт/индекс шинжлэх), сэдвийн номын санч (сургалт судалгааны бодлогод мэргэжлийн дэмжлэг) нарын тусгайлсан үүрэг шинээр зохицуулагдсан.
12.	28.3-28.7, 28.13, 28.14	Номын сангийн ажилтанд мэргэжлээрээ тасралтгүй ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх тогтвортой ажилласны урамшуулал олгох; өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн урамшуулал олгох; нийгмийн баталгааг бусад төрийн албан хаагчаас дордуулахгүй байх зарчим — бүрэн шинэ, санхүүгийн шууд үр дагавартай зохицуулалт.
13.	30.1	Номын сангийн салбарт хүний нөөц бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, чадамжийн сургалтад төрөөс бодлого, санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг тусгайлан хуульчилсан зүйл.
14.	32.7	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улсын хэмжээний номын сангийн статистик мэдээллийг нэгтгэх, дүн

№	Төслийн зүйлийн дугаар	Шинэ зохицуулалтын агуулга
		шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тодорхой чиг үүргийг шууд хуульчилсан (2014 оны хуульд байгууллагын бүрэн эрхийн ерөнхий заалт байсан ч ийм тодорхой статистик/хяналт-шинжилгээний чиг үүрэг тусгайлан заагаагүй).
15.	17.1.2 (хэсэгчлэн)	Улсын төсвийн хөрөнгөөр хэвлэгдсэн хүүхдийн бүтээлээс Үндэсний номын санд 5 ширхэг, Хүүхдийн төв номын санд 2 ширхэг гэж тусад нь ялган заасан нь өмнөх хуулийн ерөнхий “хүүхдэд зориулсан бүтээлээс 2 ширхэг” гэснээс илүү нарийвчилсан, өргөтгөсөн зохицуулалт.

Хүснэгт 1 болон Хүснэгт 2-оос үзвэл, Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн 10 гаруй зохицуулалт нь шинэ бөгөөд бусад зохицуулалт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Номын сангийн тухай хуулийн зохицуулалт байна.

Өөрөөр хэлбэл, Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөл нь 2014 оны хуулийн үндсэн бүтэц, зохицуулалтын дийлэнх хэсгийг (номын сангийн ангилал, зөвлөлийн тогтолцоо, сан хөмрөгийн бүрдүүлэлт, заавал авах хувь, уншигчийн эрх, төрийн байгууллагын бүрэн эрх) хэвээр хадгалсан. Харин шинэлэг талыг дараах гурван чиглэлээр авч үзэж болохоор байна. Үүнд:

1. Цахим шилжилт. Цахим номын сангийн үйл ажиллагааг тусдаа бүлэг болгож (24-26 дугаар зүйл), академик номын сангийн мэргэжил-арга зүйн төвд нэгдсэн каталог, хиймэл оюун ухаан, хуулбарлалт шалгах программ нэвтрүүлэх үүрэг өгсөн (12.3).

2. Хүний нөөцийн мэргэшил. Судлаач номын санч, сэдвийн номын санч гэсэн шинэ мэргэжлийн ангилал, тэдгээрийн тусгай эрх, үүргийг нэвтрүүлсэн (3.1.2-3.1.4, 12.4, 27.3-27.4).

3. Ажилтны нийгмийн баталгаа. Мэргэжлээрээ тасралтгүй ажилласан 5 жил тутамд 6 сарын цалинтай тэнцэх урамшуулал олгох зохицуулалт (28.3-28.7) нь санхүүгийн хувьд хамгийн өндөр үр дагавартай, бүрэн шинэ зохицуулалт болно.

Иймд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслөөр шинээр бий болж буй 10 гаруй зохицуулалтын хүрээнд зардлыг тооцсон. Харин өөрчлөгдөөгүй буюу өмнө нь байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

iii. Зардлын төрөл

Энэхүү судалгааг Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.[4] Уг аргачлалын 1.5-д зардлыг хуулийн этгээдийн зардал, иргэний үүсэх зардал, төрийн байгууллагын зардал гэсэн 3 төрлөөр хийж гүйцэтгэхээр заасан.[5]

Өмнөх хэсэгт дурдсанчлан Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөл нь 3 агуулгын хүрээнд шинэчлэлт хийж байгаа бөгөөд хүний нөөцийн мэргэшилийн хүрээнд төр, иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгээгүй байна.

Иймд, тус хуулийн төслийн зардлын төрлийн цахим шилжилт болон ажилтны нийгмийн баталгааны хүрээнд төрд үүсэх зардлын тооцсон бөгөөд дараах дэд хэсэгт хуваан үзлээ.

I. Цахим шилжилттэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх зардал

1.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

II. Ажилтны нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх зардал

2.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

III. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад зардал

3.1. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

[4] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООГ ХИЙХ АРГАЧЛАЛ, https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1

[5] Мөн тэнд

iv. Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөл болон 2014 оны Номын сангийн тухай хуулийн харьцуулалт 5
Хүснэгт 2.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих хуулийн төслөөр шинэчлэн зохицуулж буй харилцаа 8
Хүснэгт 3. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт 15
Хүснэгт 4.Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил ба стандарт үйл ажиллагаа 16
Хүснэгт 5.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.3-28.7-д заасан стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ 17
Хүснэгт 6.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.13-д заасан стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ 18
Хүснэгт 7.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.3-28.13-д заасны хэрэгжүүлэх нийт хүний нөөц, минутаар 18
Хүснэгт 8.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал 19
Хүснэгт 9.Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал 20
Хүснэгт 10. Хуулийн төслийн 28 дугаар зүйлд заасан урамшуулалд шаардагдах төсөв.. 21
Хүснэгт 11.Нийт зардал 22
Хүснэгт 12.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслөөр шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүрэг 25
Хүснэгт 13.Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил ба стандарт үйл ажиллагаа 25
Хүснэгт 14.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа ба хүний нөөцийн хэрэгцээ 27
Хүснэгт 15.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөлд шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хүний нөөцийн нийт дүн, минутаар 28
Хүснэгт 16.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал 29
Хүснэгт 17.Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал 30
Хүснэгт 18.Нийт зардал 31
Хүснэгт 19.Нийт зардлын дэлгэрэнгүй задаргаа 31
Хүснэгт 20. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх нийт зардал 34
Хүснэгт 21. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагадах төсвийн задаргаа 34

1. ЦАХИМ ШИЛЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.3 болон Дөрөвдүгээр бүлэг буюу 24-26 дугаар зүйл Цахим номын сангийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. Энэхүү зохицуулалтаас Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцож үзвэл.

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.[6]

1.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөлд төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

- Засгийн газар
- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
- Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрхийг тусгасан.[7]

Хуулийн төслийн дээрх зохицуулалтаас үзвэл, “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 24-26 дугаар зүйл болон 30-33 дугаар зүйлд цахим номын сангийн үйл ажиллагааг тусгасан хэдий ч үүний хэрхэн хэрэгжүүлэх талаар хуулийн төсөлд нарийвчлан зохицуулаагүй.

Тодруулбал, тус хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1-д Дижитал хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой заалтуудыг зохих дүрэм, журманд тусгаж, гэрээний загварыг батална гэж заасан. Гэвч ямар дүрэм журам болон гэрээний загварыг хэн батлах нь тодорхойгүй.

Боловсрол шинжлэх ухааны яамнаас 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн номын сан, урлаг заалны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ - Номын сангийн компьютер, принтер цахим тоног төхөөрөмжийг авах Нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан.[8] Уг тендерийн нийт төсөвт өртөг 195,000,00,00 /нэг зуун ерэн таван сая, долоон зуун мянган төгрөг/ байна.

---

[6] Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООГ ХИЙХ АРГАЧЛАЛ, https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1

[7] Хуулийн төслийн 31-33 дахь заалтыг үзнэ үү.

[8] https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1772116578930

Мөн, хуулийн төслийн 25 дугаар зүйлд Цахим номын сангийн үйлчилгээ ба мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд 25.2-д Цахим номын сангийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, нууцлалын бодлогыг хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ гэж заасан.

Гэвч яаж дэмжлэг үзүүлэх талаар зохицуулалтыг тусгаагүй тул Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөлд заасан цахим шилжилттэй холбоотой зохицуулалтаас төрд үүсэх зардлыг тооцох боломжгүй байна.

Иймд, “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн цахим шилжилттэй холбоотой төрийн хүлээх үүрэг, тусламж дэмжлэгийг талаарх зохицуулалтыг нарийвчлах шаардлагатай. Ингэсний дараагаар 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох, ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц болон гарах зардлыг тодорхойлох боломж бүрдэнэ.

2. АЖИЛТНЫ НИЙГМИЙН БАТАЛГААТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.3-28.7-д номын сангийн ажилтны нийгмийн баталгааны зохицуулалтыг тусгасан. Энэхүү зохицуулалтаас Төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцож үзвэл.

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төсөлд төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

Хүснэгт 3. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох зохицуулалт	**Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага**
28.3. Номын сангийн байгууллагад мэргэжлээрээ тасралтгүй ажилласан хугацааг үндэслэн таван жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр ажилтанд тогтвортой ажилласны урамшууллыг дараах хэмжээгээр олгоно.	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуульд тусгайлан заагаагүй. Судлаачийн зүгээс Музейн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д заасны үндэслэн уг үүргийг хэрэгжүүлэгчийн Засгийн газар гэж тодорхойлсон.[9]
28.4. Энэ хуулийн 28.3-т заасан тогтвортой ажилласны урамшууллыг ажилтанд тухайн хугацааг бүрэн хангасан тохиолдолд нэг удаа олгоно	
28.5. Энэ хуулийн 28.3-т заасан ажилласан хугацааг төрийн болон орон нутгийн өмчийн номын санд болон академик, сургуулийн, тусгай номын санд мэргэжлээрээ ажилласан нийт хугацааг үндэслэн тооцно.	
28.6. Тогтвортой ажилласны урамшууллыг тооцох үндсэн цалин гэдэгт тухайн ажилтны урамшуулал авах эрх үүссэн өдрийн үндсэн цалинг ойлгоно.	
28.7. Номын сангийн ажилтан нэг байгууллагаас нөгөө номын сангийн байгууллагад шилжин ажилласан тохиолдолд энэ хуулийн 28.3-т заасан ажилласан хугацааг тасралтгүй ажилласан нөхцөлд нэгтгэн тооцно.	
28.13. Номын сангийн ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр ажлаас чөлөөлөгдөхөд тухайн байгууллагад ажилласан хугацаа, мэргэжлийн ур чадвар, салбарын хөгжилд оруулсан хувь нэмрийг харгалзан нэг удаагийн тэтгэвэрт гарах урамшуулал олгоно.	

[9] Музейн тухай хууль, 2021, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16160832622081

Өөрөөр хэлбэл, чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх чиг үүрэг буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов. Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дахь аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй.

Хүснэгт 4.Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил ба стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	**Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ**	**Стандарт үйл ажиллагаа**
Засгийн газар	- тогтвортой ажилласны урамшууллыг ажилтанд олгох	- Ажилтны мэргэжлээрээ ажилласан нийт хугацааг тооцох, баталгаажуулах - 5 жилийн шаттай таарсан ажилтныг илрүүлэх, жагсаалт гаргах - Өөр байгууллагаас шилжин ирсэн ажилтны өмнөх ажилласан хугацааны лавлагаа, тодорхойлолт авах, нягтлах - Урамшуулал тооцох үндсэн цалинг тодорхойлох - Урамшуулал олгох тушаал/шийдвэр бэлтгэх, батлуулах - Урамшууллын жилийн эрэлтийг төсөвт тусгах, санхүүжилт төлөвлөх - Урамшуулал олгосон бүртгэл хөтлөх, дээд байгууллагад тайлагнах
Засгийн газар	- Өндөр насны тэтгэвэрт гарах урамшуулал	- Тэтгэвэрт гарах үндэслэл бүхий өргөдлийг хүлээн авах, шалгах - Тухайн байгууллагад ажилласан хугацаа, мэргэжлийн ур чадвар, салбарт оруулсан хувь нэмрийг үнэлэх - Урамшууллын хэмжээг тодорхойлох, шийдвэр гаргах - Урамшуулал олгох, санхүүжилтийг төсөвт тусгах

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг**ийг тус тус тооцно.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо статистик тоон мэдээлэлд тулгуурлан тооцсон болно.

Тооцоог хийхийн нийт номын сангийн ажилтнаас дараах тооцоог гаргасан. Тодруулбал, Ажилтны нийт мэргэжлээрээ ажиласан хугацааг тооцох, баталгаажуулах тохиодлыг 1547 гэж, 5 жилийн ажилласан ажилтныг илрүүлэх, жагсаалт гаргах тохиолдлыг 1, шилжин ирсэн ажилтны өмнөх ажилласан хугацааны лавлагаа авах, нягтлах тохиолдлыг 1547, Урамшуулал тооцох үндсэн цалинг тодорхойлох, тохиолдлыг нийт тохиолдлын 10 хувиар буюу 154 байхаар тооцсон. Харин Урамшууллын жилийн эрэлтийг төсөвт тусгах, санхүүжилтийг төлөвлөх, Урамшуулал олгосон бүртгэл хөтлөх, дээд байгууллагад тайлагнах тохиодллын тоог тус бүр 1 байхаар тооцсон болно.

А. Тогтвортой ажилласны урамшуулал (28.3-28.7)

Хүснэгт 5.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.3-28.7-д заасан стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Хугацаа /мин/	Нийт /мин/
Тогтвортой ажилласны урамшууллыг ажилтанд олгох	Ажилтны мэргэжлээрээ ажилласан нийт хугацааг тооцох, баталгаажуулах	1,547	10	15,470
	5 жилийн ажилласан ажилтныг илрүүлэх, жагсаалт гаргах	1	4800	4,800
	Шилжин ирсэн ажилтны өмнөх ажилласан хугацааны лавлагаа авах, нягтлах	1,547	3	4,641
	Урамшуулал тооцох үндсэн цалинг тодорхойлох	1,547	10	15,470
	Урамшуулал олгох тушаал/шийдвэр бэлтгэх, батлуулах	1,547	10	15,470
	Урамшууллын жилийн эрэлтийг төсөвт тусгах, санхүүжилт төлөвлөх	1	480	480
	Урамшуулал олгосон бүртгэл хөтлөх, дээд байгууллагад тайлагнах	1	240	240
	Нийт			**56,571**

Б. Өндөр насны тэтгэвэрт гарах урамшуулал (28.13)

Харин “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.13-д заасан Өндөр насны тэтгэвэрт гарах урамшууллын тохиолдлын тоог нийт тохиолдлын тооны 10 хувь байхаар тооцсон. Харин хугацааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт заасан хуулийн этгээдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хугацааг тооцох загвараас авсан.[10]

Хүснэгт 6.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.13-д заасан стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	**Стандарт үйл ажиллагаа**	**Тохиолдлын тоо**	**Хугацаа /мин/**	**Нийт /мин/**
Өндөр насны тэтгэвэрт гарах урамшуулал	Тэтгэвэрт гарах үндэслэл бүхий өргөдлийг хүлээн авах, шалгах	154	30	4,620
	Ажилласан хугацаа, ур чадвар, хувь нэмрийг үнэлэх	154	120	18,480
	Урамшууллын хэмжээг тодорхойлох, шийдвэр гаргах	154	60	9,240
	Урамшуулал олгох (баримт бичиг бүрдүүлэх)	154	30	4,620
	Санхүүжилтийг төсөвт тусгах (жилд нэгтгэсэн)	1	240	240
	Нийт			**37,200**

Дээрх хоёр хүснэгтээс нийт хүний нөөцийг минутыг тодорхойлбол:

Хүснэгт 7.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн 28.3-28.13-д заасны хэрэгжүүлэх нийт хүний нөөц, минутаар

Чиг үүрэг	**Нийт минут**
А. Тогтвортой ажилласны урамшуулал (28.3-28.7)	**56,571**
Б. Өндөр насны тэтгэвэрт гарах урамшуулал (28.13)	**37,200**
НИЙТ	**93,771**

[10]*Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт,* ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООГ ХИЙХ АРГАЧЛАЛ, https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1өдөр= ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 х 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 х 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 8.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Төрийн байгууллага	**93,771**	**96.000**	**0.98**

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн” Номын сангийн ажилтны нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалтын хэрэгжүүлэхэд Засгийн газарт шинээр 1 албан хаагчийн орон тоог үүсгэх шаардлагатай.

Нэмэгдэх ачаалал нь гагцхүү Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөлд заасан номын сангийн ажилтны нийгмийн баталгааны зохицуулалтыг хэрэгжүүлэхд шаардагдах ажлын ачаалал юм.

Уг хуулийн төсөл батлагдах тохиолдолд холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэх ба уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнээс хамаарч улсын төсөвт бусад шууд бус зардал нэмэгдэнэ.

2.3. Үүсэх зардлыг урьдчилан тооцох

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс гарах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцдог.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан төрийн захиргааны албан тушаалын дундаж цалин (ТЗ-4 зэрэглэл, сард 1,471,000 төгрөг)[11]-ийг үндэслэв. Жилийн цалин 17,652,000 төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ (11.5%)[12] 2,029,980 төгрөг, нийт хүний нөөцийн 1 орон тооны жилийн зардал **19,681,980** төгрөг болно.

Энэ зардлыг **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардлыг гарна.

Хүснэгт 9.Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Засгийн газар	**0.98**	**19,681,980**	**19,288,340**
Нийт			**19,288,340**

[11]Төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээ — Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 3 дугаар хавсралт (2025.01.01-ний өдрөөс мөрдөгдсөн). https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342157411

[12]Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ (11.5%) — Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, мөн өмнөх зардлын тооцооны тайлангуудад (жишээ нь, “Эрх, чөлөөг хамгаалах цагдаагийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг шинэчлэх тухай” хуулийн төслийн зардлын тооцооны судалгаа) ашигласан жишиг хувь хэмжээ.

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна. Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 28 дугаарз зүйлийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамгийн багадаа тэдгээр албан хаагчдын ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, түүний туслах, зөвлөх, биет төлөөлөгчийн ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал нэмэгдэнэ. Засгийн газрын төсвийн зарцуулалтын задаргаа нээлттэй бус байх тул Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн албан хаагчдын ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралтын жишгээр 5,395,434 төгрөгөөр тооцов[13] (бичиг хэрэг, шуудан холбоо, тоног төхөөрөмж, түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засвар, элэгдэл хорогдол зэрэг). Үүнээс 0.98-ыг тооцож гаргавал 5,287,525 төгрөг болно.

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад ойролцоогоор **0.98** хүний нөөц шаардлагатай бөгөөд түүнд хамаарах санхүүгийн нийт зардал **24,575,865** төгрөг байна. Үүний **19,288,340** төгрөг нь хүний нөөцийн зардал бол материаллаг зардал **5,287,525** төгрөг байна.

Түүнчлэн, Хуулийн төслийн 28.3 дугаар зүйлд заасны дагуу номын сангийн ажилтан мэргэжлээрээ тасралтгүй ажилласан 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал авах эрхтэй гэжээ. Үүний зардлыг тооцохдоо Үндэсний номын сангийн 112, нийтийн номын сангийн (365 сан, дунджаар 2 ажилтнаар баримжаалж) 730, ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн 705 номын санч буюу нийт 1547 ажилтан байхаар тооцов.[14] Академик болон бусад номын сангийн ажилтны албан ёсны тоо баримт олдоогүй тул судалгаанд оруулаагүй, энэ нь тооцоог бодит хэмжээнээс бага гаргах эрсдэлтэй болохыг анхаарна уу). Тухайн жилд хуулийн төслийн 28 дугаар зүйлд заасан урамшууллыг авах боломжийг 10% хувь гэвэл 154.7 ажилтан урамшуулал авахаар байна.

Хүснэгт 10. Хуулийн төслийн 28 дугаар зүйлд заасан урамшуулалд шаардагдах төсөв

Үзүүлэлт	Хэмжээ
Номын сангийн нийт ажилтан (баримжаа)	1547
5 жилийн шаттай таарах хувь (баримжаа)	10%
Урамшуулал авагчийн тоо (жилд)	154.7

[13]Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлын дүн (5,395,434 төгрөг: бичиг хэрэг, шуудан холбоо, тоног төхөөрөмж, тавилга, түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засвар, газрын төлбөр, элэгдэл хорогдол) — “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн зардлын тооцооны тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, ХЗДХЯ-нд бэлтгэсэн, 2024 оны VI сар, Хүснэгт 6, тал 12

[14]Номын сангийн нийт ажилтны тоо (1,547) нь эх сурвалж №6, №7, №8-д дурдсан тоон дээр үндэслэсэн баримжаа тооцоо (нийтийн номын сан 365 × дунджаар 2 ажилтан = 730; Үндэсний номын сан 112; ерөнхий боловсролын сургуулийн номын санч 705). Академик, тусгай номын сангийн ажилтны албан ёсны нэгдсэн тоо баримт олдоогүй тул хамруулаагүй болно. 5 жилийн тутам урашуулах авах тархалтыг нийт тархалтын (10%) нь тооцсон.

Үзүүлэлт	Хэмжээ
1 хүнд ногдох урамшуулал (6 сарын цалин + НДШ)	9,840,990
Нийт жилийн зардал	1,522,401,153

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 11.Нийт зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал (А)	Материаллаг Зардал (Б)	Бусад зардал (С)
Нийт Зардлын хэмжээ	**19,288,340**	**5,287,525**	**1,522,401,153**
Нийт зардал		**1,546,977,018**	

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд жилд нийт **1,546,977,018** (нэг тэрбум таван зуун дөчин зургаан сая есөн зуун далан долоон мянга арван найман)-ийн зардал төрд үүсэхээр байна. Үүний **98.4** хувийг тус хуулийн төслийн 28 дугаар зүйлд заасан тогтвортой ажилласны урамшуулал эзэлж байна.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ:

1. Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх:
2. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
4. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх

- *Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх*

Ажилтны мэргэжлээрээ ажилласан нийт хугацааг тооцох, баталгаажуулах, 5 жилийн нэмэгдлийг тооцох, зэрэг үйл ажиллагааг нэгдсэн хүний нөөцийн цахим бүртгэлийн системд шилжүүлбэл автоматаар, бага зардлаар гүйцэтгэх боломжтой.

Харин урамшууллын хэмжээг эцэслэн шийдвэрлэх, тушаал батлуулах зэрэг эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах үйл ажиллагааг бүрэн цахимжуулах боломжгүй бөгөөд заавал эрх бүхий албан тушаалтны шийдвэр, гарын үсэг шаардлагатай хэвээр байна

- *Тохиолдлыг тоог багасгах боломж байгаа эсэх*

Номын сангийн нийт ажилтны тоо (1,547), урамшуулал эрх үүсэх ажилтны тоо (жилд ~155) нь бодит хүний нөөцийн бүтцээс шууд үүдэлтэй тул тохиолдлын тоог хиймлээр багасгах боломжгүй.

Гэвч “шилжин ирсэн ажилтны лавлагаа авах, нягтлах” үйл ажиллагааг нэгдсэн бүртгэлийн санд тулгуурлан гүйцэтгэвэл (одоогийн 1,547 тохиолдол бүрт биш) зөвхөн бодит шилжилт хийсэн ажилтны тоогоор (жилд ойролцоогоор 3-5%, буюу 50-80 орчим хүнээр) хязгаарлах боломжтой. Энэ нь тохиолдлын тоог мэдэгдэхүйц бууруулна.

- *Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх*

Урамшуулал тооцох, шийдвэр гаргах ажлыг тухай бүрт биш, жилд 1-2 удаагийн багц (batch) хэлбэрээр гүйцэтгэвэл захиргааны давталтыг бууруулах боломжтой.

Тогтвортой ажилласны урамшуулал нь хуулиар тодорхой хугацаанд (5 жил тутам) олгогддог тул давтамжийг цаашид багасгах боломжгүй.

- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх*

Дээд байгууллагад тайлагнах тайлангийн агуулгыг хялбарчилж, зөвхөн үндсэн үзүүлэлт (авагчийн тоо, нийт дүн)-ээр хязгаарлаж болох бөгөөд дэлгэрэнгүй тайлан шаардлагагүй.

Харин урамшуулал тооцох, олгох шийдвэрийн үндэслэл болох ажилласан хугацааны нотолгоо зэрэг мэдээллээс татгалзах боломжгүй. Учир нь энэ нь шийдвэр гаргахад шаардлагатай эрх зүйн үндэслэл юм.

3. НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД ЗАРДАЛ

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн цахим шилжилт, ажилтны нийгмийн баталгаанаас бусад зохицуулалтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллахад үүсэх зардлыг тооцож үзвэл.

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

3.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Хуулийн төслөөс төрийн байгууллагад шинээр бий болох өмнөх хэсэгт давхцаагүй дараах чиг үүргийг тодорхойлов[15]:

Хүснэгт 12.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслөөр шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүрэг

№	Гүйцэтгэх байгууллага	Хуулийн зүйл, заалт	Шинэ чиг үүрэг
1	Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв	12.2, 12.3	Нэгдсэн каталог, нэгдсэн цахим номын сан, мэдээллийн сан үүсгэх; хуулбарлалт шалгах программ хангамжийг нэгдмэл байдлаар нэвтрүүлэх; хиймэл оюун ухаан ашиглах ажлыг зохион байгуулах
2	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	32.7	Улсын хэмжээний номын сангийн статистик мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх
3	Хүүхдийн төв номын сан	11.1	Хүүхдийн болон сургуулийн номын санд (844) мэргэжил-арга зүйн удирдлага үзүүлэх

Өөрөөр хэлбэл, Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх чиг үүрэг буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов. Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дахь аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй.

Хүснэгт 13.Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил ба стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	Нэгдсэн каталог, нэгдсэн цахим номын сан, мэдээллийн сан үүсгэх; хуулбарлалт шалгах программ хангамжийг нэгдмэл байдлаар	- Гишүүн 88 номын сангийн каталогийн бичлэгийг хүлээн авах, стандартчилах, давхардал арилгах (сард 1 удаа) - Нэгдсэн цахим номын сан, мэдээллийн санг тасралтгүй удирдах, шинэчлэх

	нэвтрүүлэх; хиймэл оюун ашиглах ажлыг зохион байгуулах	- Хуулбарлалт шалгах программын хэрэглээний сургалт, дэмжлэг (сургууль тус бүрт жилд 1 удаа) - Хиймэл оюун ухаан ашиглах чиглэлийн сургалт зохион байгуулах (улиралд 1 удаа) - Мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгөх (сард, гишүүн номын сан бүрт)
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	- Улсын хэмжээний номын сангийн статистик мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	- Номын сан тус бүрээс улирлын тайлан, статистик мэдээ хүлээн авах, нягтлах - Улсын хэмжээний тайланг нэгтгэх, дүн шинжилгээ хийх - Хяналт-шинжилгээ, үр дагаврын үнэлгээний тайлан бэлтгэх (жилд 1 удаа)
Хүүхдийн төв номын сан (11.1)	- Хүүхдийн болон сургуулийн номын санд (844) мэргэжил-арга зүйн удирдлага үзүүлэх	- Сургуулийн номын санд (844) арга зүйн зөвлөгөө өгөх (жилд 1 удаа) - Бүсийн сургалт зохион байгуулах (21 аймаг, нийслэл

3.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг**ийг тус тус тооцно.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо статистик тоон мэдээлэлд тулгуурлан тооцсон болно.

Тооцоог хийхийн нийт номын сангийн ажилтнаас дараах тооцоог гаргасан. Тодруулбал, Ажилтны нийт мэргэжлээрээ ажиласан хугацааг тооцох, баталгаажуулах тохиодлыг 1547 гэж, 5 жилийн ажилласан ажилтныг илрүүлэх, жагсаалт гаргах тохиолдлыг 1, шилжин ирсэн ажилтны өмнөх ажилласан хугацааны лавлагаа авах, нягтлах тохиолдлыг 1547, Урамшуулал тооцох үндсэн цалинг тодорхойлох, тохиолдлыг нийт тохиолдлын 10 хувиар буюу 154 байхаар тооцсон. Харин урамшууллын жилийн эрэлтийг төсөвт тусгах, санхүүжилтийг төлөвлөх, Урамшуулал олгосон бүртгэл хөтлөх, дээд байгууллагад тайлагнах тохиодллын тоог тус бүр 1 байхаар тооцсон болно.

Хүснэгт 14.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа ба хүний нөөцийн хэрэгцээ

Төрийн байгууллагын нэр	**Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ**	**Стандарт үйл ажиллагаа**	**Тохиолдлын тоо**	**Хугацаа /мин/**	**Нийт /мин/**
Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	Нэгдсэн каталог, нэгдсэн цахим номын сан, мэдээллийн сан үүсгэх; хуулбарлалт шалгах программ хангамжийг нэгдмэл байдлаар нэвтрүүлэх; хиймэл оюун ашиглах ажлыг зохион байгуулах	Гишүүн 88 номын сангийн каталогийн бичлэгийг хүлээн авах, стандартчилах, давхардал арилгах (сард 1 удаа)	1,056	45	47,520
		Нэгдсэн цахим номын сан, мэдээллийн санг тасралтгүй удирдах, шинэчлэх	1	48,000	48,000
		Хуулбарлалт шалгах программын хэрэглээний сургалт, дэмжлэг (сургууль тус бүрт жилд 1 удаа)	88	240	21,120
		Хиймэл оюун ухаан ашиглах чиглэлийн сургалт зохион байгуулах (улиралд 1 удаа)	4	480	1,920
		Мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгөх (сард, гишүүн номын сан бүрт)	1,056	30	15,470
		Нийт			**150,240**

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	Улсын хэмжээний номын сангийн статистик мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Номын сан тус бүрээс улирлын тайлан, статистик мэдээ хүлээн авах, нягтлах	5,884	15	**88,260**
		Улсын хэмжээний тайланг нэгтгэх, дүн шинжилгээ хийх	1	4,800	**4,800**
		Хяналт-шинжилгээ, үр дагаврын үнэлгээний тайлан бэлтгэх (жилд 1 удаа)	1	9,600	**9,600**
		Нийт			**102,660**
Хүүхдийн төв номын сан (11.1)	Хүүхдийн болон сургуулийн номын санд (844) мэргэжил-арга зүйн удирдлага үзүүлэх	Сургуулийн номын санд (844) арга зүйн зөвлөгөө өгөх (жилд 1 удаа)	844	60	**50,640**
		Бүсийн сургалт зохион байгуулах (21 аймаг, нийслэл	22	480	**10,560**
		Нийт			**61,200**

Эдгээрийг байгууллага бүрээр нэгтгэж үзвэл,

Хүснэгт 15.Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төсөлд шинээр бий болсон цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх хүний нөөцийн нийт дүн, минутаар

Чиг үүрэг	Зарцуулах хүний нөөцийн минут
А. Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	**150,240**
Б. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	**102,660**
В. Хүүхдийн төв номын сан (11.1)	**61,200**
НИЙТ	**314,100**

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1өдөр= ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 х 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 х 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 16.Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	**Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/**
А. Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	150,240	96.000	**1.56**
Б. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	102,660		**1.07**
В. Хүүхдийн төв номын сан (11.1)	61,200		**0.63**
Нийт	314,100		**3.27**

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь заалтыг хэрэгжүүлэхэд Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төвд **1.56** хүний нөөцийн орон тоо, мөн хуулийн төслийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь заалтыг хэрэгжүүлэхэд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **1.07** хүний нөөцийн орон тоо, харин хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд Хүүхдийн төв номын санд **0.63** хүний нөөц шинээр шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд **нийт 3.27** төрийн албан хаагчийн орон тоог шинээр бий болгох шаардлагатай.

Уг хуулийн төсөл батлагдах тохиолдолд холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэх ба уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнээс хамаарч улсын төсөвт бусад шууд бус зардал нэмэгдэнэ.

3.3. Үүсэх зардлыг урьдчилан тооцох

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг эрэгжүүлэхтэй холбоотой төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс гарах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцдог.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан төрийн захиргааны албан тушаалын дундаж цалин (ТЗ-4 зэрэглэл, сард 1,471,000 төгрөг)[16]-ийг үндэслэв. Жилийн цалин 17,652,000 төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ (11.5%)[17] 2,029,980 төгрөг, нийт хүний нөөцийн 1 орон тооны жилийн зардал **19,681,980** төгрөг болно.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардлыг гарна.

Хүснэгт 17.Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
А. Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	**1.56**	**19,681,980**	**30,703,888.8**
Б. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	**1.07**	**19,681,980**	**21,059,718.6**
В. Хүүхдийн төв номын сан (11.1)	**0.63**	**19,681,980**	**12,399,647.4**
Нийт			**64,163,254.8**

[16]Төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээ — Засгийн газрын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, 3 дугаар хавсралт (2025.01.01-ний өдрөөс мөрдөгдсөн). https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342157411

[17]Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ (11.5%) — Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, мөн өмнөх зардлын тооцооны тайлангуудад (жишээ нь, “Эрх, чөлөөг хамгаалах цагдаагийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг шинэчлэх тухай” хуулийн төслийн зардлын тооцооны судалгаа) ашигласан жишиг хувь хэмжээ.

3.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна. Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамгийн багадаа тэдгээр албан хаагчдын ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, түүний туслах, зөвлөх, биет төлөөлөгчийн ажлын байр, компьютер тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал нэмэгдэнэ. Засгийн газрын төсвийн зарцуулалтын задаргаа нээлттэй бус байх тул Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн албан хаагчдын ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралтын жишгээр 5,395,434 төгрөгөөр тооцов[18] (бичиг хэрэг, шуудан холбоо, тоног төхөөрөмж, түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засвар, элэгдэл хорогдол зэрэг).

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 3.27 хүний нөөц шаардлагатай бөгөөд үүнийг нэг албан хаагчид ноогдох төгрөг /5,395,434/-өөр үржүүлбэл **17,643,069** төгрөг болж байна.

Хүснэгт 18.Нийт зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг Зардал	Бусад зардал
Нийт Зардлын хэмжээ	**64,163,254**	**17,643,069**	**-**
Нийт зардал		**81,806,323**	

Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийн цахим шилжилт, нийгмийн баталгаанаас бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт **81,806,323** (наян нэгэн сая найман зуун зургаан мянга, гурван зуун хорин гурван төгрөг)-ийн зардал төрд үүсэхээр байна.

Хүснэгт 19.Нийт зардлын дэлгэрэнгүй задаргаа

[18]Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлын дүн (5,395,434 төгрөг: бичиг хэрэг, шуудан холбоо, тоног төхөөрөмж, тавилга, түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засвар, газрын төлбөр, элэгдэл хорогдол) — “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн зардлын тооцооны тайлан, Хууль зүйн үндэсний хүрээлэн, ХЗДХЯ-нд бэлтгэсэн, 2024 оны VI сар, Хүснэгт 6, тал 12

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт зардал зардал
А. Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв (12.2, 12.3)	1.56	30,703,888.8	8,416,877	**39,120,765**
Б. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (32.7)	1.07	21,059,718.6	5,773,114	**26,832,832**
В. Хүүхдийн төв номын сан (11.1)	0.63	12,399,647.4	3,399,123	**15,798,770**
Нийт	**3.27**	**64,163,254**	**17,643,069**	**81,806,323**

Үүнийг байгууллагаар задалж үзвэл, Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв **39,120,765,** Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад **26,832,832,** Хүүхдийн төв номын санд **15,798,770 төгрөг тус тус шаардлагатай.**

3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ:

1. Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх:
2. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
4. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх

- *Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх*

Номын сангийн каталогийн бичлэг хүлээн авах, стандартчилах, статистик тайлан хүлээн авах, нягтлах зэрэг үйл ажиллагааг нэгдсэн цахим системээр бүрэн автоматжуулах боломжтой. Энэ нь хуулийн төслийн 12.3, 32.7 дугаар зүйлийн зорилготой шууд нийцнэ.

Харин мэргэжил-арга зүйн зөвлөгөө өгөх, бүсийн сургалт зохион байгуулах зэрэг ур чадвар дамжуулах, харилцан ярилцах шинжтэй үйл ажиллагааг бүрэн цахимжуулах боломжгүй, гэхдээ цахим хурлын хэлбэрээр хослуулах боломжтой.

- *Тохиолдлыг тоог багасгах боломж байгаа эсэх*

Гишүүн номын сангийн тоо (88), нийт номын сангийн тоо (1,471), сургуулийн номын сангийн тоо (844) нь номын сангийн тогтолцооны бодит бүтцээс тогтоогдсон тул тохиолдлын тоог багасгах боломжгүй.

Харин “Хуулбарлалт шалгах программын хэрэглээний сургалт”-ыг сургууль тус бүрт биш, бүс/аймгийн төвлөрсөн сургалт хэлбэрээр (жишээ нь 21 бүсэд) зохион байгуулбал 88-аас 21 болж тохиолдлын тоог мэдэгдэхүйц бууруулах боломжтой.

- *Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;*

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх статистик тайланг улирал тутам (жилд 4 удаа) биш хагас жилд 1 удаа (жилд 2 удаа) болгож багасгавал тохиолдлын тоог 5,884-аас ойролцоогоор 2,942 болгож, 44,130 минут (0.46 орон тоо) хэмнэх боломжтой.

Гэвч энэ нь номын сангийн салбарын бодит цаг үеийн байдлыг тодорхойлох, хурдан арга хэмжээ авах чадварыг сулруулах эрсдэлтэй тул тэнцвэртэй шийдвэр гаргах шаардлагатай. Жишээ нь гол үзүүлэлтийг улирал тутам, дэлгэрэнгүй тайланг хагас жилд нэг удаа гэж ялгаж болно.

- *Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх*

Хиймэл оюун ухаан ашиглах чиглэлийн сургалтыг эхний 1-2 жилд хойшлуулж, зөвхөн нэгдсэн каталог, хуулбарлалт шалгах программ зэрэг үндсэн чиг үүргийг тэргүүн ээлжинд хэрэгжүүлж болно. Энэ нь эхний жилийн зардлыг бууруулна.

Улсын хэмжээний тайланг нэгтгэх дүн шинжилгээний зарим агуулгыг (жишээ нь дэлгэрэнгүй харьцуулсан шинжилгээ) хойшлуулж, зөвхөн үндсэн статистик мэдээллийг тэргүүн ээлжинд боловсруулж болно.

ДҮГНЭЛТ

“Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, иргэн, хуулийн этгээдэд учрах зардлыг урьдчилан тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн дагуу Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төв, Хүүхдийн төв номын сан зэрэг байгууллагууд өөрсдийн чиг үүргийн дагуу энэ харилцаанд оролцохоор байна. Хуулийн төсөлд иргэн, аж ахуй нэгжид шинээр мөнгөн болон цаг хугацааны үүрэг хүлээлгээгүй байх тул гагцхүү төрд учрах зардлыг тооцсон болно.

Хүснэгт 20. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх нийт зардал

Зардлын чиглэл	Дүн (төгрөгөөр)
I. Цахим шилжилттэй холбоотой зохицуулалт	Тодорхой бус зохицуулалтын улмаас тооцох боломжгүй
II. Ажилтны нийгмийн баталгаатай холбоотой зохицуулалт (28.3-28.13)	**1,546,977,018**
i. Тогтвортой ажилласны нэмэгдэл .	1,522,401,153
ii. Нэмэгдлийг тооцоход шаардагдах хүний нөөцийн зардал	24,575,865
III. Бусад чиг үүрэг (12.2-12.3, 32.7, 11.1)	**82,253,918**
i. Академик номын сангийн мэргэжил-арга зүйн төвд үүсэх хүний нөөцийн зардал	39,120,765,
ii. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүсэх хүний нөөцийн зардал	26,832,832
iii. Хүүхдийн төв номын санд үүсэх хүний нөөцийн зардал	15,798,770
НИЙТ (II + III)	**1,629,230,936**

Нийт хуулийн төслийг хэрэгжүүлэхэд жилд ойролцоогоор **1,629,230,936** төгрөгийн зардал төрд үүсэхээр тооцогдож байгаа бөгөөд үүний дийлэнх хувийг (98.3%) 28 дугаар зүйлд заасан урамшуулал эзэлж байна.

Хүснэгт 21. Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагадах төсвийн задаргаа

Төрөл	Хүний нөөцтэй холбоотойгоор үүсэх зардал	Материаллаг зардал	Бусад зардал
Нийт зардлын хэмжээ	**80,953,144**	**22,876,639**	**1,522,401,153**
Нийт зардал			**1,629,230,936**

Дээрхээс дүгнэн үзвэл;

1. Тогтвортой ажилласны урамшуулал нь нийт зардлын дийлэнх хувийг эзэлж байгаа тул уг зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд урьдчилан тусгаж, олон жилийн хугацаанд тэгш хуваарилан төлөвлөх шаардлагатай.

2. Цахим шилжилттэй холбоотой зохицуулалт (24-26, 30-33 дугаар зүйл)-ыг хэрэгжүүлэх дүрэм, журам, хариуцах байгууллагыг хуулийн төсөлд тодорхой болгосны дараа холбогдох зардлыг нэмж тооцох шаардлагатай. Иймд, хуулийн төсөлд заасан цахим шилжилтийн зохицуулалт, цаашлаад түүнд төрөөс дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай.

3. Зөвхөн цахим шилжилт гэлтгүйгээр “Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай” хуулийн төслийн зохицуулалтад төслийн үр нөлөө хийх замаар сайжруулах шаардлагатай. Тухайлбал, хуулийн төслийн 28 дугаар зүйлд Номын сангийн ажилтны нийгмийн баталгааг эрх зүйн орчныг тусгасан хэдий ч үүнийг хэн хэрэгжүүлэх талаар хуулийн төсөлд огт тусгагаагүй байна. Энэ мэт хуулийн төслийн боловсруулахад явцад үүссэн алдаа, дутагдлыг дахин анхаарах шаардлагатай.

4. Статистик, тайлан мэдээг цахим системээр авах, боловсруулах, төвлөрсөн сургалт зохион байгуулах замаар ажлын ачаалал, зардлыг цаашид бууруулах боломжтой тул холбогдох журамд эдгээрийг тэргүүн ээлжинд тусгах нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

1. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол, 4 дүгээр хавсралт — "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал". *legalinfo.mn* — https://legalinfo.mn/mn/detail?lawId=207336&showType=1
2. "Номын сангийн үйл ажиллагааг дэмжих тухай" хуулийн төслийн эх бичвэр (захиалагчаас ирүүлсэн, огноо/дугаар одоогоор эцэслэгдээгүй)
3. "Номын сангийн тухай" хууль (2014 он) — хүчинтэй хууль, харьцуулалтын үндэс. *legalinfo.mn* — https://legalinfo.mn/mn/detail/10844
4. Засгийн газрын 2024.12.25-ны өдрийн 238 дугаар тогтоол — "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай", 3 дугаар хавсралт. *legalinfo.mn* — https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342157411
5. Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль — ажил олгогчийн ХД шимтгэлийн хувь хэмжээ (11.5%)
6. УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар, "Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан", Улаанбаатар, 2021 он (тал 5, 7, 9–11) — их дээд сургууль (88), нийтийн номын сан (365), Үндэсний номын сан (112 ажилтан), сургуулийн номын сан (844, номын санч 705) зэрэг тоо баримт. www.parliament.mn/files/cb5091438a714064b4bea2f446cd0a73/?d=1 ; www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_1
7. ССАЖЗЯ, "Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан /2025 он/", 2026.06.09. https://mocsty.gov.mn/news/fDlGUwy3oaeC3984XPV9Qqto0s7tsFnt